ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/143/СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг<br>Утас: 70432545<br>цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |
| *ЕБС* | *Ерөнхий боловсролын сургууль* |
| *НДШ* | *Нийгмийн даатгалын шимтгэл* |
| *ХАОАТ* | *Хүн амын орлогын албан татвар* |
| *ЗДТГ* | *Засаг даргын тамгын газар* |
| *СТСХ* | *Санхүү, Төрийн сангийн хэлтэс* |
| *БШУЯ* | *Боловсрол шинжлэх ухааны яам* |

## Агуулга


1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....10

3. Аудитын тайлан....11

3.1. Ерөнхий зүйл....11

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....12

3.4. Материаллаг байдал....12

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....12

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....13

3.7. Шилэн дансны мэдээлэл....14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....15

3.9. Аудитын илрүүлэлт....15

Залруулсан алдаа....15

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....

Аудитын зөвлөмж....16

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....16

4. Менежментийн захидал....16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....16

# 1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.28. № 2/118
танай ______________-ны №______________-т

БУЛГАН СУМЫН 1-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 1-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын 1-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургалтын чанар, элсэлтийн шалгалтын бодит байдал /суралцагчийн сурлагын түвшин, суралцагчийн сурах ээлтэй орчин бүрдүүлсэн / зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг/ агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

*Төсвийн төлөвлөлт зарцуулалт бодит бус, санхүүгийн тайлангаар тушаал шийдвэргүй хүүхдийн хоолны мах муутгаж зарлагдсан, хүнсний муудах материал их хэмжээгээр нөөцөлсөн, хөрөнгийн тооллого хийгээгүй, нүүрс хэтрүүлэн зарцуулсан, нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцсон, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хөрөнгийн зардалд тавих дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ,*

2102059Э

*мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 107,705,302.06 | 83,802,559.43 |
| 33 | АВЛАГА | 50,000.00 | 59,000.00 |
| 335 | Бусад авлага | 50,000.00 | 59,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 50,000.00 | 59,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 107,655,302.06 | 83,743,559.43 |
| 351 | Түүхий эд материал | 414,020.00 | 38,400.00 |
| 35130 | Эм боох материал | 414,020.00 | 38,400.00 |
| 354 | Хангамжийн материал | 107,241,282.06 | 83,705,159.43 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 750,000.00 | 400,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 53,508,247.80 | 48,511,838.40 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 24,639,850.00 | 18,285,225.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 633,460.00 | 236,960.00 |
| 35460 | Хүнсний материал | 26,607,520.03 | 16,201,136.03 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,102,204.23 | 70,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,571,226,111.34 | 1,538,696,037.31 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,571,226,111.34 | 1,538,696,037.31 |
| 392 | Биет хөрөнгө | 1,524,226,111.34 | 1,491,696,037.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,472,873,699.00 | 1,472,873,699.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -147,861,086.76 | -172,363,835.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 23,500,000.00 | 23,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -23,500,000.00 | -23,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 389,582,072.80 | 393,168,424.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -354,008,260.73 | -368,970,073.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 203,969,875.50 | 221,292,373.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -120,582,438.17 | -137,765,482.73 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,750,000.00 | 22,750,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,531,249.73 | -13,806,249.69 |
| 39217 | Ном | 69,033,499.43 | 74,517,181.43 |
| 393 | Биет бус хөрөнгө | 47,000,000.00 | 47,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 275,000.00 | 275,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -275,000.00 | -275,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 47,000,000.00 | 47,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,678,931,413.40 | 1,622,498,596.74 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,678,761,787.89 | 1,622,498,596.73 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,678,761,787.89 | 1,622,498,596.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 699,055,330.28 | 699,055,330.28 |
| 51101 | Өмч: - төрийн | 699,055,330.28 | 699,055,330.28 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -286,239,272.78 | -342,502,463.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -286,239,272.78 | -286,239,272.78 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -56,263,191.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,265,945,730.39 | 1,265,945,730.39 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,679,101,038.90 | 1,622,498,596.73 |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,525,235,184.50 | 1,771,315,674.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,385,654.50 | 31,906,782.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,385,654.50 | 31,906,782.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,385,654.50 | 31,906,782.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 400,000.00 | 400,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,080,500.00 | 3,029,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,905,154.50 | 28,477,782.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 105,884,830.00 | 111,157,692.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,386,964,700.00 | 1,628,251,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,494,070.00 | 2,450,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 494,070.00 | 1,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | 950,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 85,522,800.00 | 85,156,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 85,522,800.00 | 85,156,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 18,867,960.00 | 23,551,392.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 18,867,960.00 | 23,551,392.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,595,176,096.01 | 1,827,578,865.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,595,176,096.01 | 1,827,578,865.16 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,510,866,036.01 | 1,666,785,425.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,108,023,668.00 | 1,311,882,487.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,107,945,309.00 | 924,295,966.29 |
| 210102 | Нэмэгдэл | 78,359.00 | 264,707,286.82 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 122,879,233.89 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 137,900,750.00 | 164,245,489.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 137,900,750.00 | 112,819,819.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 13,226,370.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 10,665,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 2,666,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 24,867,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,035,301.50 | 59,657,582.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,953,946.00 | 13,191,557.00 |
| 210302 | Түлш, халаалт | 63,649,355.50 | 45,942,525.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 432,000.00 | 523,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,552,657.00 | 19,732,403.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,206,600.00 | 1,185,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,667,370.00 | 8,012,260.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,000,666.00 | 1,897,954.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 210,520.00 | 860,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,300.00 | 669,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,883,001.00 | 7,107,089.63 |
| 2105 | Нормативт зардал | 55,267,895.98 | 43,857,494.09 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 566,080.00 | 7,200,520.00 |
| 210502 | Хоол, хүнс | 53,491,815.98 | 33,600,274.09 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,210,000.00 | 3,056,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,202,210.00 | 2,360,910.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,122,210.00 | 2,360,910.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 540,000.00 | 540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 540,000.00 | 540,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 386,200.00 | 392,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 386,200.00 | 392,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,957,353.53 | 64,117,059.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,280.00 | 710,669.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,673,600.00 | 4,483,784.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 110,212,473.53 | 58,922,605.94 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 84,310,060.00 | 160,793,439.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 82,311,660.00 | 50,736,792.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 19,014,960.00 | 23,551,392.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 45,456,600.00 | 27,185,400.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 110,056,647.63 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 110,056,647.63 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -69,940,911.51 | -56,263,191.16 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -84,748,822.08 | -56,263,191.16 |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,497,330,030.00 | 1,742,837,892.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,480,500.00 | 3,429,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,480,500.00 | 3,429,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,480,500.00 | 3,429,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 400,000.00 | 400,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,080,500.00 | 3,029,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,492,849,530.00 | 1,739,408,892.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,386,964,700.00 | 1,628,251,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,494,070.00 | 2,450,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 494,070.00 | 1,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | 950,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 85,522,800.00 | 85,156,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн | 85,522,800.00 | 85,156,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 18,867,960.00 | 23,551,392.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 18,867,960.00 | 23,551,392.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,497,330,030.00 | 1,742,837,892.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,497,330,030.00 | 1,742,837,892.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,413,019,970.00 | 1,582,044,452.37 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,086,818,342.00 | 1,316,939,343.37 |
| 210101 | Үндсэн цалин | 748,526,594.00 | 926,323,822.66 |
| 210102 | Нэмэгдэл | 230,634,005.00 | 267,736,286.82 |
| 210104 | Урамшуулал | 88,596,463.00 | 122,879,233.89 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 155,524,530.00 | 159,194,228.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 155,520,530.00 | 107,768,558.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,000.00 | 13,226,370.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 10,665,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 2,666,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 24,867,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,418,351.00 | 53,772,157.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,953,946.00 | 13,191,557.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,032,405.00 | 40,057,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 432,000.00 | 523,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,238,875.00 | 15,729,014.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 513,800.00 | 1,185,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,018,440.00 | 8,012,260.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,000,666.00 | 1,897,954.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 414,020.00 | 860,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,300.00 | 670,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,191,649.00 | 3,103,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 62,517,252.00 | 29,739,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 630,100.00 | 6,818,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 59,683,900.00 | 19,863,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,203,252.00 | 3,057,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,061,510.00 | 650,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,061,510.00 | 650,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 540,000.00 | 540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 540,000.00 | 540,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 386,200.00 | 392,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 386,200.00 | 392,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,514,910.00 | 5,088,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,150,830.00 | 602,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,364,080.00 | 4,485,110.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 84,310,060.00 | 160,793,439.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 82,311,660.00 | 50,736,792.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 19,014,960.00 | 23,551,392.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 45,456,600.00 | 27,185,400.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 110,056,647.63 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 110,056,647.63 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 662,055,330.28 | 885,291,362.04 | 1,324,564,763.62 | 2,871,911,455.94 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 662,055,330.28 | 885,291,362.04 | 1,324,564,763.62 | 2,871,911,455.94 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 21,241,191.67 | 21,241,191.67 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 699,055,330.28 | 1,265,945,730.39 | -286,239,272.78 | 1,678,761,787.89 |
| D01 | 2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 699,055,330.28 | 1,265,945,730.39 | -286,239,272.78 | 1,678,761,787.89 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 699,055,330.28 | 1,265,945,730.39 | -286,239,272.78 | 1,678,761,787.89 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -56,263,191.16 | -56,263,191.16 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 699,055,330.28 | 1,265,945,730.39 | -342,502,463.94 | 1,622,498,596.73 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,739,463,100.00 | 1,604,700,752.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,739,463,100.00 | 1,604,700,752.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,658,422,600.00 | 1,577,515,352.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,279,163,100.00 | 1,316,939,343.37 |
| 210101 | Үндсэн цалин | 901,232,100.00 | 926,323,822.66 |
| 210102 | Нэмэгдэл | 283,301,600.00 | 267,736,286.82 |
| 210104 | Урамшуулал | 94,629,400.00 | 122,879,233.89 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 172,687,000.00 | 159,194,228.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 121,520,600.00 | 107,768,558.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,791,600.00 | 13,226,370.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,233,300.00 | 10,665,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,558,200.00 | 2,666,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,583,300.00 | 24,867,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 86,929,600.00 | 53,772,157.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,743,400.00 | 13,191,557.00 |
| 210302 | Түлш, халаалт | 75,386,200.00 | 40,057,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 523,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,005,500.00 | 11,200,014.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 834,200.00 | 1,185,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,206,800.00 | 3,483,260.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 947,300.00 | 1,897,954.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 741,500.00 | 860,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 401,700.00 | 670,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,874,000.00 | 3,103,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 101,717,200.00 | 29,739,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 501,000.00 | 6,818,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 98,858,600.00 | 19,863,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,357,600.00 | 3,057,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 650,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 650,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 540,700.00 | 540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 540,700.00 | 540,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 392,000.00 | 392,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000.00 | 392,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7987500.00 | 5087910.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,350,000.00 | 1,319,200.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,637,500.00 | 3,768,710.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81040500.00 | 27185400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 81,040,500.00 | 27,185,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 81,040,500.00 | 27,185,400.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,740,312,000.00 | 1,604,700,752.40 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,650,183,500.00 | 1,603,350,752.40 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,650,183,500.00 | 1,518,194,452.40 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 88,778,500.00 | 85,156,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 88,778,500.00 | 85,156,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,350,000.00 | 950,000.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 110.00 | 111.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 67.00 | 67.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 43.00 | 43.00 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 3,579,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,579,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,579,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1,500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 2,079,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 2,079,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 3,579,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 3,579,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,079,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. Ерөнхий зүйл

Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Г.Цэцэгмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын бараа материалын зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*

- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд  тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй боловч сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.
Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй  байна.

Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн  дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1613404.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 16134.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын  1827470.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 18274.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56432.8 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| АВЛАГА | 50.0 | 59.0 | 9.0 |
| БАРАА МАТЕРИАЛ | 107,655.3 | 83,743.6 | -23,911.7 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,571,226.1 | 1,538,696.0 | -32,530.1 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,678,931.4** | **1,622,498.6** | **-56,432.8** |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР | 277.5 | 0.0 | -277.5 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН | 1,678,653.9 | 1,622,498.6 | -56,155.3 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР** | **1,678,931.4** | **1,622,498.6** | **-56,432.8** |

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 59.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 83743.6 мянган төгрөг болж 23911.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хичээл ороогүйтэй холбоотой шинээр бараа материал бага авч үлдэгдэл материалаа зарцуулсан байгаа нь нөлөөлж байна. Бараа материалын зардлаас хүнсний материал оны эхэнд үлдэгдэл ихтэй байсан мөн оны эцэст муудах хүнсний үлдэгдэл ихтэй тайлагнасан өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1571226.1 мянган төгрөг, оны эцэст 1538696.0 мянган төгрөг болж 32530.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр төсвийн хөрөнгөөр 376.0 мянган төгрөгийн ном, БСУГ-аас 26016.5 мянган төгрөгийн хүүхдийн ширээ сандал, тоног төхөөрөмж, сурах бичиг үнэ төлбөргүй орлогоор авч хөрөнгө актлаагүй, тайлант онд хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Өр төлбөр оны эхэнд 277.5 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөгтэй байснаас тайлант онд 277.5 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст өрийн үлдэгдэлгүй байна. Аудитын тулгалтаар нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг дутуу шилжүүлж өрөөр тайлагнаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 1622498.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 56432.8 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 249109.5 мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 249109.5 мянган төгрөгийн орлогын өөрчлөлтөөс тусгай зориулалтын санхүүжилт 249109.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 235323.8 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал 230282.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 5041.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1812545.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1812545.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 1628251.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 85156.3 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 1350.0 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 1714757.5 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1714757.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1628251.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 85156.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1350.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1714757.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1628251.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 85156.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1350.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1604700.7 мянган төгрөг зарцуулж 110056.7 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1604700.7 мянган төгрөг буюу 85% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 11,244.3 |
| 81109 | Урсгал үйл ажиллагааны зардал | 30,457.7 |
| 81801 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 11,198.9 |
| 81806 | Хоол хүнс | 50,875.5 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 6,280.3 |
| **ДҮН** | | **110,056.7** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар орон нутгийн төсвөөс 1500.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 2079.0 мянган төгрөг нийт 3579.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 1500.0 мянган төгрөгөөр сургуулийн гадна орчны тохижилт хийсэн, 2079.0 мянган төгрөгөөр хогийн хашаа хийж данс бүртгэлд тусган нийт 3579.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 114, мэдээллийг огт оруулаагүй 6, мэдээлэл дутуу оруулсан 14 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 6 мэдээллийг байршуулаагүй байгааг залруулан мэдээллийг оруулсан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Булган сумын 1-р сургуульд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 3,586.3 | - | 2,780.0 | 1 | 806.3 | 60 |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 4 | 29,384.3 | 2 | 25,345.2 | 2 | 4,039.1 | 60 |
| Нийт дүн | 5 | 32,970.6 | 2 | 28,125.2 | 3 | 4,845.4 | 60 |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 35456.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3029.0 мянган төгрөгийн залруулж 32427.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 2385.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 26794.5 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, 3248.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

**Залруулсан алдаа:** Аудитаар тайлангийн үр дүнд 3029.0 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр бүртгэснийг мөнгөн орлогоор бүртгэж залруулга хийгдсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2385.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 26794.5 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага бичлээ.

1.1. *Илрүүлэлт:* Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлсөн, өмнөх онд дутуу төвлөрүүлж дахин тооцох зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, цалингийн карт хөтлөөгүй, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй 1072.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
*Шийдвэрлэсэн нь: : Төлбөрийн акт тогтоох*

1.2. *Илрүүлэлт:* Хүнсний бүтээгдэхүүн болон махыг махны гарал үүслийн бичиггүй, нийлүүлсэн, хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, мах муутгаж малын байцаагчийн дүгнэлт гарган тушаал шийдвэргүй анхан шатны баримт хангалтгүй, өмч хамгаалах комиссын дүгнэлтгүй мах зарлагдсан, байгууллагын дотоод хяналт сул байгаа 1312.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
*Шийдвэрлэсэн нь: : Төлбөрийн акт тогтоох*

1.3. *Илрүүлэлт:* Аж ахуйн нэгж, иргэн, байгууллагуудтай хоорондын тооцоо хийж анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаагүй, е баримтгүй гүйлгээ хийсэн, оны эцэст хүнсний муудах материалын үлдэгдэл их, хөрөнгө материалын тооллого хийж баталгаажуулаагүй 24794.5 мянган төгрөг, хүнсний материалаас тушаал шийдвэргүй, тухайн хүн хүлээн авч баталгаажуулсан баримтгүйгээр мах нийлүүлсэн иргэнд буцааж олгосон гэж мах зарлагдсан байна. Няравын дансаар орж байгаа мөнгөний тооцоо хийгээгүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжээгүй 2000.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих*

**Аудитын зөвлөмж:** Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3248.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар бараа материалын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***2. Бараа материал:***

2.1. Илрүүлэлт: Нүүрсний тооцоо хийж зарцуулалтыг хянаагүй, норм нормативаас хэтрүүлэн зарцуулсан, их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн, хөрөнгө материалын тооллого хийгээгүй, зарцуулалтад тавих хяналт сул байгаа 3248.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх

*2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,*

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ХОА-2021/143/СТА- |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Булган сумын ЕБ-ийн 1-р сургууль** | Мянган төгрөгөөр |

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Алдаа, зөрчлийн товч утга</th><th rowspan="2">Мөнгөн дүн</th><th>Аудитын байгууллагаас гаргасан шийдэл</th><th colspan="2">Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны</th></tr>
<tr><th>Нэр</th><th>Албан тушаал</th><th>Овог нэр</th></tr>
<tr><td></td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td></tr>
<tr><td>1</td><td>Хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, мах муутгаж малын байцаагчийн дүгнэлт гарган тушаал шийдвэргүй анхан шатны баримт хангалтгүй, өмч хамгаалах комиссын дүгнэлтгүй мах зарлагдсан, байгууллагын дотоод хяналт сул байна</td><td>1312.5</td><td>Төлбөрийн акт</td><td rowspan="6">Булган сумын ЕБ-ийн 1-р сургуулийн захирал, Нягтлан бодогч</td><td rowspan="6">Г.Цэцэгмаа, Г.Оргил</td></tr>
<tr><td>2</td><td>Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлсөн, өмнөх онд дутуу төвлөрүүлж дахин тооцох зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, цалингийн карт хөтлөөгүй, гарын үсэг зураагүй</td><td>1072.6</td><td>Төлбөрийн акт</td></tr>
<tr><td>3</td><td>Аж ахуйн нэгж, иргэн, байгууллагуудтай хоорондын тооцоо хийж баталгаажуулаагүй, е баримтгүй гүйлгээ хийсэн, хүнсний муудах материалын үлдэгдэл их, хөрөнгө материалын тооллого хийж баталгаажуулаагүй</td><td>24794.5</td><td>Албан шаардлага</td></tr>
<tr><td>4</td><td>Хүнсний материалаас тушаал шийдвэргүй, тухайн хүн хүлээн авч баталгаажуулсан баримтгүй, мах нийлүүлсэн иргэнд буцааж олгосон гэж зарлагдсан байна. Няравын дансаар орж байгаа мөнгөний тооцоо хийгээгүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжээгүй</td><td>2000.0</td><td>Албан шаардлага</td></tr>
<tr><td>5</td><td>Нүүрсний тооцоо хийж зарцуулалтыг хянаагүй, норм нормативаас хэтрүүлэн зарцуулсан, их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн,</td><td>3248.0</td><td>Зөвлөмж</td></tr>
<tr><td>6</td><td>Нэмэлт дансаар орсон мөнгөн орлогоор авсан материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байгааг үр дүнгийн тайланд залруулга хийх</td><td>3029.0</td><td>Залруулга хийсэн</td></tr>
<tr><td colspan="2">ДҮН</td><td>35456.6</td><td></td><td></td><td></td></tr>
</table>

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**